



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 2 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

“МИАТ” ТӨХК-ийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, Хөгжлийн банкны тухай хуулийн 22.1.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “МИАТ” ТӨХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн хүндрэлийг даван туулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгасугай:

а/компанийн үйл ажиллагааг хэмнэлтийн горимд шилжүүлж, санхүүгийн үйл ажиллагааг хянах, мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий менежментийн багийг 12 сарын хугацаагаар томилон ажиллуулж, явц, үр дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байх;

б/компанийн санхүүгийн үйл ажиллагаанд судалгаа, дүгнэлт хийж, цаашид компанийг үр ашигтай ажиллуулах талаар тодорхой санал боловсруулж Засгийн газарт танилцуулах.

2. “МИАТ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд 2015 оны I, II улирлын зээлийн төлбөрт зориулан нийт 8,4 (найман сая дөрвөн зуун мянган) сая ам.долларыг Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн өөрийн эх үүсвэрээс олгох арга хэмжээ авахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д даалгасугай.

3. Иргэний нисэхийн ерөнхий газрын өмчлөлд байгаа “Ангар” техник засвар үйлчилгээний байрыг “МИАТ” ТӨХК-д балансаас балансад шилжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгасугай.

4. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан менежментийн багийн ажлын удирдамжийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт, менежментийн багийн үйл ажиллагааны зардлын асуудлыг зохих журмын дагуу хууль, дүрмийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ